

Mongol - Залбирсан Дуулал - WP Psalms

Дуулал 68:1 Найрал дууны удирдаачид. Давидын дуулал. Дуу.
Бурхан босож, дайснууд нь таран бутарч, Түүнийг үзэн ядагчид
Түүний өмнөөс зугтаг.

Дуулал 5:9,10 Тэдний хэлж байгаа зүйлсэд итгэх юм юу ч үгүй.
Тэдний зүрх сэтгэл нь сүйрэл юм. Тэдний хоолой нь онгорхой
булш юм. Тэд хэлээрээ магтан хөөрөгддөг. 10 Бурхан, тэдний
гэмтэйг тунхаглаач! Өөрсдийнх нь арга залиар тэднийг
унагаач! Үй түмэн алдаа зөрчил дотор нь тэднийг хөөн гаргаач,
Учир нь тэд Таны эсрэг тэрсэлдэг билээ.

Дуулал 11:6 Тэрээр хорон муу хүн дээр тор буулгах бөгөөд Гал,
хүхэр болон түлэх салхи тэдний аяганы хувь хишиг болох юм.

Дуулал 18:14 Тэрээр Өөрийн сумнуудаа нисгэн бутрааж, Аянга
цахилгаануудаа үй олноор цахиулж, тэднийг бут ниргэсэн.

Дуулал 18:17 Тэр намайг хүчит дайснаас минь болон намайг үзэн
ядагчдаас аварсан. Учир нь тэд миний хувьд дэндүү хүчтэй
байв.

Дуулал 18:39 Та намайг тулалдаанд бэлтгэн хүч чадлаар
зэвсэглэжээ. Миний эсрэг босогчдыг миний доор Та оруулсан
билээ.

Дуулал 18:45 Харь хүмүүс сульданд доройтож, Бат цайзуудаасаа
чичрэн гарч ирдэг.

Дуулал 27:11 ЭЗЭН, Өөрийн замыг надад зааж, Дайснуудын минь
учир намайг шулуун жимээр удирдаач.

Дуулал 35:1-8 Давидын дуулал. ЭЗЭН, надтай тэмцэлдэгчидтэй
тэмцэлдээч. Надтай тулалдагчидтай тулалдаач. 2 Халхавч,
бамбайгаа барин Надад туслахаар босооч. 3 Намайг
мөрдөгчидтэй тулгарахаар жад, сүхээ сугал. Миний сэтгэлд
хандан "Би бол чиний аврал!" гэж хэл. 4 Миний амийг хайгчдыг
шившиг болгож, ичгүүрт унагаагаач. Миний эсрэг бузар мууг
сэдэгчдийг буцааж, дорд болгооч. 5 Тэднийг ЭЗЭНий тэнгэр
элчээр туугдаж буй, Салхинд хийсэх будааны хальс мэт
болгооч. 6 ЭЗЭНий тэнгэр элчээр тэднийг хөөлгөн Замыг нь
харанхуй, халтиргаатай болгооч. 7 Учир нь ямар ч
шалтгаангүйгээр тэд намайг барихаар тор тавьсан, Ямар ч
шалтгаангүйгээр тэд миний сүнсэнд нүх ухсан. 8 Түүнийг

мэдээгүй байхад сүйрлийг түүнд ирүүлж, Өөрийнх нь нуусан тор өөрийг нь бариг. Тэр л сүйрэлд түүнийг унагаагаач.

Дуулал 52:5 Харин Бурхан чамайг үүрд сөнөөнө. Тэрээр чамайг авч хаян майхнаас чинь гаргаж, Амьдын газраас чамайг үндсээр чинь суга татан хаяна. Села

Дуулал 60:12 Бурханаар дамжуулаад бид зоригтой байх бөгөөд Бидний өстнүүдийг гишгэчлэх нэгэн бол Тэр билээ.

Дуулал 66:3 Бурханд "Таны үйлс хичнээн сүрлэг вэ! Таны хүчний агуутаас дайснууд тань Таны өмнө зусардан бялдуучилна.

Дуулал 68:35 Бурхан, Өөрийн ариун газраас Та сүрдмээр байна. Израилийн Бурхан Өөрөө хүмүүст хүч чадлыг өгдөг. Бурхан магтагдах болтугай!

Дуулал 70:1 Найрал дууны удирдаачид. Давидын дуулал. Дурсгалд. Бурхан, намайг аврахаар яараач. ЭЗЭН, надад туслахаар хурдлаач.

Дуулал 71:13 Миний сүнсний дайснуудыг ичгүүрт унаган, сөнөөгөөч. Намайг хорлохыг хүсэгчдийг доромжлол, ичгүүрээр нөмөргөөч.

Дуулал 76:12 Тэрээр ноёдын сүнсийг номхтгоно. Түүнээс дэлхийн хаад айдаг юм.

Дуулал 118:10 Бүх үндэстнүүд намайг бүсэлжээ. ЭЗЭНий нэрээр би тэднийг заавал бут цохино.

Дуулал 118:12 Тэд намайг зөгийнүүд мэт хүрээлсэн. Тэд өргөст бутны дундах гал мэт унтарчээ. ЭЗЭНий нэрээр би тэднийг заавал тасална.

Дуулал 149:8,9 Тэдний хаадыг гинжээр гинжилж Ноёдыг нь төмөр дөнгөөр тушихын тулд, 9 Бичигдсэн шүүлтийг тэдэнд гүйцэтгэхийн тулд болой. Энэ бол Түүний бүх бурханлаг хүмүүст хүндэтгэл юм. ЭЗЭНийг магтагтун!

Pastor T. John Franklin
Church of Salvation, Healing, and Deliverance
COS-HAD.org